

1. Шумбагч онгоцны ханыг 12 см зузаантай болд төмрөөр хийдгийн учир юу вэ?




- Усанд норохоос сэргийлж
- Их даралтыг тэсвэрлэхийн тулд
- Махчин загасанд идүүлэхгүйн тулд
- Удаан ашиглахын тулд

2. Усанд шумбагчид далайн гүн рүү орохдоо яагаад хамгаалах тусгай өмсгөл өмсдөг вэ?



- Далайн амьтанд хазуулахаас хамгаалж
- Их даралтанд орж байгаа учраас
- Норохоос сэргийлж

3. Хажуу ханандаа ёроолоосоо 10 см, 20 см, 30 см өндөрт орших гурван нүх бүхий 40 см өндөртэй цилиндр савыг усаар дүүргэжээ. Аль нүхнээс гарсан ус хамгийн хол тусах вэ?



- Гурван нүхнээс гарсан ус адилхан зайд тусна.
- Ёроолоос 20 см ба 30 см өндөрт орших нүхнээс
- Ёроолоос 10 см өндөрт орших нүхнээс
- Ёроолоос 20 см өндөрт орших нүхнээс
- Ёроолоос 30 см өндөрт орших нүхнээс

4. Хатуу бие, шингэн, хий нь гадны үйлчлэлийг хэрхэн дамжуулдаг вэ?

- Хатуу
 - Тал тал тийш ижил хэмжээтэй
- Шингэн ба хий
 - Гадны үйлчлэлийн чиглэл дагуу


5. Битүү савтай шингэнийг 10 кПа даралтаар шахав. Савны хананд ямар даралт учрах вэ?

- Даралт учрахгүй
- 10 кПа даралт учирна
- Доод хананд 10 кПа даралт учирна.
- Зөвхөн хажуу хананд даралт учирна.


6. Автомашины тоормосны систем нь шингэний ямар шинж чанарыг үндэслэсэн бэ?

- Шингэн шахагдахгүй. Даралтыг зүг бүртээ дамжуулдаг.
- Шингэн нягт ихтэй. Даралтыг зүг бүртээ дамжуулдаг.
- Шингэн урсамтгай. Даралтыг зөвхөн хажуу тийш дамжуулдаг.
- Шингэн савныхаа хэлбэрийг дагадаг. Даралтыг зөвхөн дээш дамжуулдаг.

7. Зурагт харилцан адилгүй хэлбэртэй 5 саванд ижил түвшинтэй болтол ус хийснийг харуулав. Аль савны ёроолд даралт их байх вэ?



- a. 3-р сав хамгийн бага суурийн талбайтай тул
 - b. 2 ба 4 -р савны суурийн талбай их тул
 - c. Бүгд ижил
 - d. 4-р саванд их масстай ус байгаа тул
 - e. 1 ба 5 –р саванд их масстай ус байгаа тул
8. Дэнсний хоёр таваг дээр тавьсан цилиндр савнууд тэнцвэрт оршино. Савнуудад ижил 500 гр ус хийвэл :



- a. Савны ёроол дахь даралт ижил байх уу?
.....
- b. Дэнсний тэнцвэр алдагдах уу?
.....